

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019.01.14

Дугаар А-19/010

“Худалдаа, хөгжлийн банкны байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого”-ын шинэчилсэн найруулгыг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банкны дүрэм”-ийн 9 дүгээр зүйлийн 9.10.8 дахь заалт, “Худалдаа, хөгжлийн банкны дотоодод мөрдөгдөх заавар, журмын төсөл боловсруулах, батлуулах, хүчингүй болгох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Худалдаа, хөгжлийн банкны байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого”-ын шинэчилсэн найруулгыг энэхүү тушаалын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.
2. Энэ тушаалыг 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг нийт газар, хэлтэс, нэгжийн ажилтнуудад тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Худалдаа, хөгжлийн банкны заавар, журмын цахим эмхэтгэл”-д холбогдох өөрчлөлтийг оруулахыг Эрсдэлийн удирдлагын газар (Д.Дэлгэрмаа)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 12/1425 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Ж.Энх-Амгалан)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

О.ОРХОН



Гүйцэтгэх захирлын 2019 оны  
19/010 тоот тушаалын хавсралт 1

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ БАЙГАЛЬ ОРЧИН,  
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО  
(Шинэчилсэн найруулга)**

**Гарчиг**

- Нэг. Нийтлэг үндэслэл  
Хоёр. БОНХ-ын бодлогын хүрээнд баримтлах зарчим  
Гурав. БОНХ-ын бодлогын хэрэгжилт  
Дөрөв. Хяналт  
Тав. Тайлагнал  
Хавсралт 1: Олон улсын стандартууд  
Хавсралт 2: Хориотой үйл ажиллагааны жагсаалт

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ  
БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО  
(Шинэчилсэн найруулга)**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Худалдаа, хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)-ны Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого (цаашид “Бодлого” гэх)-ын зорилго нь олон улсын тэргүүн туршлагад нийцүүлэн харилцагчийн байгаль орчин, нийгмийн хариуцлага (цаашид “БОНХ” гэх)-ын эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, бууруулах улмаар зээлийн шийдвэр гаргах явцдаа тусган ажиллаж, банкны олгосон санхүүжилт болон харилцагчийн бизнесийн үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.
- 1.2. Бодлого нь банкны БОНХ-ын талаар баримтлах зарчим, удирдлага, хяналтын тогтолцоог тодорхойлсон үндсэн баримт бичиг байх ба Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлэх заавар (цаашид “заавар” гэх)-аар дамжиж хэрэгжинэ.
- 1.3. Банк нь Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого, Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлэх заавар, байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй салбаруудад баримтлах бодлого, гарын авлага, сургалт, БОНХ-ын үнэлгээний арга аргачлал, эрсдэлийн ангилал, хяналт ба тайлагналаас бүрдсэн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн цогц системтэй байна.

**Хоёр. БОНХ-ын бодлогын хүрээнд баримтлах зарчим**

- 2.1. Банк нь хүний эрх, хөдөлмөрийн эрхийн болон байгаль орчны менежментийг үйл ажиллагаандаа сайн хэрэгжүүлдэг харилцагчдыг санхүүжүүлэх чиглэл баримталж, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь дунд болон өндөр харилцагчдын хувьд үр ашигтай хамтран ажиллах замаар харилцагчийн БОНХ-ын эрсдэлийг бууруулж ажиллана.
- 2.2. Банк нь Бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм зааврыг мөрдөн ажиллахаас гадна **Хавсралт 1**-т дурдсан олон улсын гэрээ хэлэлцээр, протоколын үзэл баримтлалыг өөрийн үйл ажиллагаа болон санхүүгийн хэлцэлүүддээ хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг зорино. Үүнд:
  - 2.2.1. НҮБ-ын Даян дэлхийн гэрээ (UN Global Compact);
  - 2.2.2. НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилга: Байгаль орчны болон тогтвортой хөгжлийн талаарх санхүүгийн байгууллагуудын тунхаглал (UNEP Finance Initiative: Statement by financial institutions on the environment and sustainable development);

- 2.2.3. Үндэстэн дамнасан корпораци болон нийгмийн бодлогын талаарх Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зарчмын гурван талт тунхаглал (ILO Tripartite Declaration of Principles concerning Multinational Enterprises and Social Policy);
- 2.2.4. Олон улсын санхүүгийн корпораци (цаашид “ОУСК” гэх)-ийн Гүйцэтгэлийн 8 стандарт (IFC 8 Performance Standards);
- 2.2.5. Монгол Улсын Тогтвортой санхүүгийн холбоо (цаашид “ТоС холбоо” гэх)-ны Тогтвортой санхүүжилтийн 8 зарчим;
- 2.2.6. Бүс ба Зам санаачилгын Ногоон хөрөнгө оруулалтын зарчмууд (Green Investment Principles for the Belt and Road Initiative).  
(ГЗ-ын 2019-11-05-ны А-19/600 тоот тушаалаар 2.2.5, 2.2.6 заалт нэмэв)
- 2.3. Банк нь бизнесийн зарим салбаруудыг БОНХ-ын илүү их эрсдэл учруулах магадлалтай салбар гэж үзэн доорхи салбаруудад тусгайлан бодлого боловсруулж ажиллана. Үүнд:
  - 2.3.1. “Уул уурхайн салбарт баримтлах санхүүжилтийн бодлого”;
  - 2.3.2. “Барилгын салбарт баримтлах санхүүжилтийн бодлого”;
  - 2.3.3. “Малын гаралтай түүхий эд материал бэлтгэн нийлүүлэх, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарт баримтлах санхүүжилтийн бодлого”.
- 2.4. Банк нь ногоон зээл буюу байгаль орчинд ээлтэй зээлийг дэмжин ажиллах ба ногоон зээлд дараах төрлийн зээлүүд багтана.
  - 2.4.1. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлт, холбогдох бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж;
  - 2.4.2. Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох байшин барилга, засвар, шинэчлэлтийн ажил, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж;
  - 2.4.3. Байгаль орчны бохирдлыг бууруулах, сэргийлэх үйл ажиллагаа, нөхөн сэргээлт, болон хог хаягдал бууруулалт, дахин боловсруулалт, хогноос эрчим хүч гарган авах үйл ажиллагаа;
  - 2.4.4. Байгаль орчинд ээлтэй байгалийн баялаг болон газар ашиглалтын менежмент, байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуй;
  - 2.4.5. Эх газрын болон усан доорх биологийн олон төрөл зүйлийн хамгаалалт;

- 2.4.6. Бохирдол бага үүсгэдэг тээврийн хэрэгсэл болон тэдгээрт зориулсан дэд бүтэц;
  - 2.4.7. Тогтвортой ус болон хаягдал усны менежмент;
  - 2.4.8. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэрэгслүүд болон мэдээллээр хангах систем;
  - 2.4.9. Экологийн үр ашигтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, технологи, болон холбогдох үйл ажиллагаа;
  - 2.4.10. Үндэсний эсвэл олон улсын стандартад нийцсэн ногоон барилга;
  - 2.4.11. Бусад байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйл ажиллагаа.
- 2.5. Банк нь зээлийн үйл ажиллагаандаа байгаль орчинд ээлтэй байх, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх зарчмыг баримтлах ба зээл хүсэгчийн эрхэлж буй бизнес, зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа нь нийгэм, хувь хүн, байгаль орчинд хор нөлөөгүй байх шаардлагыг хангасан байх ёстой. Үүнтэй холбоотойгоор Банк нь **Хавсралт 2**-т заасан “Хориотой үйл ажиллагааны жагсаалт”-д багтсан бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, үйл ажиллагааны салбаруудыг санхүүжүүлэхээс татгалзана.
- 2.6. Банк нь тогтвортой санхүүжилт олгох зорилтын хүрээнд БОНХ-ын эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, бууруулах улмаар зээлийн шийдвэр гаргах явцдаа тусган ажиллана.

### **Гурав. БОНХ-ын бодлогын хэрэгжилт**

- 3.1. Эрсдэлийн удирдлагын хороо нь байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй салбаруудад баримтлах санхүүжилтийн бодлогыг батлах үүрэгтэй.
- 3.2. Зээлийн хороод нь зээлийн шийдвэр гаргахдаа Эрсдэлийн удирдлагын хорооны баталсан байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй салбаруудад баримтлах санхүүжилтийн бодлого, энэхүү Бодлого, зааврыг баримтлан байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ, дүгнэлтийг харгалзан үзэж, эцсийн шийдвэрийг гаргана.
- 3.3. Эрсдэлийн удирдлагын газар нь данс хариуцсан ажилтнууд, эрсдэлийн шинжээч нарт бодлогын талаар БОНХ-ын сургалт явуулах, мэдлэг мэдээллээр хангах үүрэгтэй.
- 3.4. БОНХ-ын хяналтын ажилтны (цаашид “БОНХХА” гэх) хүсэлтээр Хуулийн газар нь Монгол улсын байгаль орчны болон холбогдох бусад хууль, журам, тогтоомжийн талаар зөвлөгөө, мэдээллээр хангах үүрэгтэй.

- 3.5. Банк нь энэхүү бодлогыг үр ашигтай хэрэгжүүлэх үүднээс олон улсын стандартад нийцсэн, үр дүнтэй үнэлгээний арга аргачлалыг ашиглах ба анхан шатны болон нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэнэ.
- 3.6. БОНХ-ын анхан шатны үнэлгээ нь харилцагчийн болон тухайн зээлийн зарцуулалтын байгаль орчин, нийгмийн эрсдэлийн түвшинг эхний байдлаар тодорхойлж, цаашид авах арга хэмжээний зааварчилгааг өгөх зорилготой.
- 3.7. Анхан шатны үнэлгээгээр БОНХ-ын эрсдэлийн түвшин нь дунд буюу шар, өндөр буюу улаан ангилалд багтаж буй зээлийн хувьд зааврын дагуу нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэх ба нарийвчилсан үнэлгээг харилцагчийн үйл ажиллагаа болон зээлийн зарцуулалтанд хийнэ.
- 3.8. Харилцагчийн нарийвчилсан үнэлгээ:
  - 3.8.1. Харилцагчийн нарийвчилсан үнэлгээ нь харилцагчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг удирдах чадвар, хандах хандлага зэргийг тодорхойлох зорилготой байна.
  - 3.8.2. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлох харилцагчийн нарийвчилсан үнэлгээний аргачлал нь дараах асуудлуудыг тодруулахад чиглэсэн байна.
    - 3.8.2.1. Хариуцлага: Харилцагч нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах зорилгоор хүлээсэн үүрэг амлалт, хариуцлагаа ухамсарласан эсэх;
    - 3.8.2.2. Чадамж: Харилцагч нь Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн систем (цаашид “БОНЭМС” гэх)-ийг удирдан зохион байгуулах, хариуцлагаа сайжруулах чадвартай эсэх;
    - 3.8.2.3. Харилцагчийн түүх: Харилцагч нь байгаль орчин, нийгмийн холбогдолтой хууль, журам зөрчих, аваар осол гаргах гэх мэт байгаль орчин, нийгмийн асуудлууд үүсгэсэн эсэх, түүнийг хэрхэн шийдвэрлэж байсан түүх.
  - 3.8.3. Харилцагчийн нарийвчилсан үнэлгээний аргачлал нь харилцагчийнхаа үйл ажиллагааг үнэлэхдээ тухайн салбарын олон улсын стандартуудтай харьцуулдаг бөгөөд асуулт бүрийн хариулт нь харилцагчийн нөхцөл байдлаас хамаарах ба дараах байдлаар ангилагддаг.
    - 3.8.3.1. “Салбарын стандартаас дээгүүр” гэдэг нь тухайн салбартаа тэргүүлэгч зэргийн үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. Жишээлбэл: Нийгмийн сайн харилцааг хэрэгжүүлдэг, хувь нийлүүлэгчдийн бүлэгт оролцдог, эсвэл үйл ажиллагаандаа хамааралтай тогтвортой хөгжлийн талаарх санааг дэвшүүлдэг харилцагч нар орно.

- 3.8.3.2. “Салбарын стандарт” гэдэг нь олон улсын стандартад нийцдэг ба түүнд төрийн байгууллагын хууль ёсны шаардлагыг хангах эсвэл нийтээр хүлээн зөвшөөрсөн үйл ажиллагааг хэлнэ.
- 3.8.3.3. “Салбарын стандартаас доогуур” гэдэг нь үйл ажиллагаанаас үүссэн БОНХ-тай холбоотой эрсдэлийг шийдвэрлэх бодлого болон процедур нь дутмаг эсвэл байхгүй байхыг хэлнэ.
- 3.8.3.4. “Хангалтгүй” гэдэг нь БОНХ-тай холбоотой эрсдэлийг бууруулахыг эрмэлздэггүй эсвэл бүр хүлээн зөвшөөрдөггүй байгууллагуудыг хэлнэ. Ийм компаниуд ихэвчлэн БОНХ-ын асуудлуудын талаар маш бага мэдээлэл өгдөг, эсвэл бүр ямар ч мэдээлэлгүй байдаг.

### 3.9. Зээлийн зарцуулалтын нарийвчилсан үнэлгээ:

- 3.9.1. Зарцуулалтын нарийвчилсан үнэлгээ нь харилцагчийн үндсэн үйл ажиллагаанаас үл хамааран тодорхой зээлийн зориулалтын түвшинд үнэлгээ өгөх зорилготой. Өөрөөр хэлбэл тухайн зээлээр санхүүжүүлж буй төсөл, үйл ажиллагаанаас үүсч болох байгаль орчин, нийгмийн эрсдэлийн түвшин, түүнээс үүсэх сөрөг үр нөлөөллөөр тодорхойлогдоно.
- 3.9.2. Зээлийн зарцуулалтын нарийвчилсан үнэлгээ нь дараах үндсэн үзүүлэлтүүдээр эрсдэлийн түвшинг тогтооно.
  - 3.9.2.1. Байгаль орчны эрсдэл: Тухайн зээлийг олгосноор үүсч болзошгүй байгаль орчны асуудлууд, түүнд амьтдын амьдрах орчин, биологийн төрөл зүйл, газрын баялаг ашиглалт, бохирдол, байгаль орчны хууль эрх зүй, хууль дүрэм, журам зэрэгт нөлөөлөх хүчин зүйл.
  - 3.9.2.2. Нийгмийн эрсдэл: Тухайн зээлийг олгосноор үүсч болзошгүй нийгмийн асуудлууд, түүний дотор хүний эрх, хөдөлмөр, ажлын байрны нөхцөл байдал, нийгмийн эрүүл мэнд болон аюулгүй байдал, газар эзэмшил болон албадан нүүлгэлт, уугуул оршин суугчдад болон соёлын өвд нөлөөлөх гэх мэт.
- 3.9.3. Өндөр эрсдэлтэй салбарууд болох барилга, уул уурхай, малын гаралтай түүхий эд материал боловсруулах салбаруудын хувьд тусгайлан боловсруулсан зарцуулалтын нарийвчилсан үнэлгээгээр эрсдэлийн түвшинг тогтооно.
- 3.9.4. Харилцагчийн зээлийн зориулалтын эрсдэлийг зээлийн зарцуулалтын нарийвчилсан үнэлгээнүүдийг ашиглан А түвшин буюу өндөр эрсдэлтэй, В түвшин буюу дунд эрсдэлтэй, С түвшин буюу бага эрсдэлтэй гэж үнэлнэ. Зээлийн зарцуулалтын нарийвчилсан үнэлгээгээр харилцагчийн зээлийн зориулалтыг ОУСК-ийн Гүйцэтгэлийн 8 стандартад заасны дагуу доорх 3 эрсдэлийн түвшинд ангилна.

- 3.9.4.1. А түвшин: Нийгэм болон байгаль орчинд нөхөн сэргээгдэх боломжгүй, олон янзаар нөлөөлдөг эсвэл тохиолдож байгаагүй томоохон сөрөг нөлөө үзүүлэх зээлийн зориулалт
  - 3.9.4.2. В түвшин: Байгаль орчин болон нийгэмд хязгаарлагдмал сөрөг нөлөөтэй ба эрсдэлийн түвшинг бууруулах боломжтой зээлийн зориулалт
  - 3.9.4.3. С түвшин: Байгаль орчин, нийгмийн эрсдэл нь хамгийн бага эсвэл ямар нэгэн сөрөг нөлөөгүй зээлийн зориулалт
- 3.10. Харилцагчийн болон зарцуулалтын үнэлгээний үр дүнгээс хамаарч харилцагчид нөхцөл шаардлага тавих эсэхийг БОНХХА шийдвэрлэнэ. БОНХХА-ны тавьсан нөхцөл шаардлагууд нь зээлийн гэрээнд тусгагдаж, зааварт заасны дагуу нөхцөл шаардлагын биелэлтэд данс хариуцсан ажилтан хяналт тавьж ажиллана.
- 3.11. Банк нь бүх төрлийн бизнесийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг БОНХ-ын эрсдэлийн түвшингээс нь хамааруулан ялгаатай тогтоох бөгөөд энэхүү шаардлагыг харгалзан зээлийн шийдвэр гаргана.
- 3.12. Зарим нөхцөлд банкны шийдвэр нь тухайн үеийн хамгийн шинэ, бодитой мэдээ мэдээлэл дээр үндэслэн гарч болно.
- 3.13. БОНХ-тай холбоотой сөрөг асуудал ихтэй бөгөөд банкнаас тавьсан БОНХ-ын нөхцөл, шаардлагыг удаа дараалан биелүүлээгүй харилцагчидтай Банк харилцаагаа зогсоох буюу зээл олгохоос татгалзах хүртэл арга хэмжээг авч болно.
- 3.14. БОНХ-ын үнэлгээ, харилцагчийн зээлийн хүсэлтийг судлах явцад бүрдүүлсэн баримтуудыг БОНХХА нь хадгална.

#### **Дөрөв. Хяналт**

- 4.1. ББГ, салбарын данс хариуцсан ажилтнууд нь зээлийн судалгаа хийхдээ харилцагчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг хийх бөгөөд зээлийн эргэн хяналтыг хийж, БОНХ-ын эрсдэлд хяналт тавина.
- 4.2. Эрсдэлийн шинжээч болон БОНХХА нь данс хариуцсан ажилтны гүйцэтгэсэн үнэлгээнд хяналт тавьж өөрийн санал, дүгнэлтийг тусгах ба Бодлогын хэрэгжилтэд хяналт тавина.

#### **Тав. Тайлагнал**

- 5.1. ЭУГ-ын БОНХХА нь БОНЭМС-ийн талаарх тайлан, мэдээг зааварт дурдсаны дагуу зээлийн хороонд сар бүр, шаардлагатай тохиолдолд банкны гүйцэтгэх удирдлага, дотоодын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагад тайлагнана.



5.2. БОНХХА нь Бодлого, заавар, Монгол улсын болон олон улсын байгаль орчны хууль эрх зүйн талаарх болон бусад холбогдох мэдээллийг банкны дотоод сүлжээнд байршуулан банкны нийт ажилтнуудад мэдээлнэ.

## **Хавсралт 1: Олон улсын стандартууд**

### **1. НҮБ-ын Даян дэлхийн гэрээ:**

Нэгдсэн үндэстний байгууллагын (цаашид НҮБ гэх) Даян дэлхийн гэрээ нь Гүйцэтгэх захирлын шийдвэрээр НҮБ-ын зорилтууд болон нийтлэг тогтвортой хөгжлийн зарчмуудыг сайн дураар хэрэгжүүлэх санаачилга юм.

Даян дэлхийн гэрээ нь төрийн болон хувийн байгууллагуудын удирдлагад тулгуурлан тогтвортой хэм хэмжээ, практикийг хөгжүүлж, хэрэгжүүлэх мөн түүнийг нийтэд ил тод байлгах бодлогын орчин юм. Нийт 160 гаруй улсын 12000 гаруй оролцогчдыг эгнээндээ нэгтгэсэн Даян дэлхийн гэрээ нь дэлхийн хэмжээнд тогтвортой удирдлага, компанийн нийгмийн хариуцлагын хамгийн том хэм хэмжээ болж байгаа юм.

Уг гэрээнд гарын үсэг зурсан байгууллагууд нь Тогтвортой байдлын нийтлэг 10 зарчмуудын дагуу өөрсдийн үйл ажиллагаагаа явуулах хүлээдэг.

Эдгээр 10 зарчмууд нь:

#### **Хүний эрх:**

Зарчим 1: Бизнес эрхлэгчид нь олон улсад хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг хамгаалах явдлыг дэмжиж, хүндэтгэнэ.

Зарчим 2: Бизнес эрхлэгчид нь хүний эрхийг урвуулан ашиглахгүй.

#### **Хөдөлмөр эрхлэлт:**

Зарчим 3: Бизнес эрхлэгчид нь нэгдэн нийлэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр хийх эрхийг бүрэн утгаар нь хэрэгжүүлж үр өгөөжтэй байлгах үүргийг хүлээнэ.

Зарчим 4: Бизнес эрхлэгчид нь хүч хэрэглэсэн болон албадан хөдөлмөр эрхлэлтийн бүх хэлбэрийг устгана.

Зарчим 5: Бизнес эрхлэгчид нь хүүхдийн хөдөлмөрийг үр дүнтэй хална.

Зарчим 6: Бизнес эрхлэгчид нь хөдөлмөр эрхлэлт болон ажлын байран дахь ялгаварлан гадуурхах явдлыг устгана.

#### **Байгаль орчин:**

Зарчим 7: Бизнес эрхлэгчид нь байгаль орчинг сүйтгэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжиж ажиллана.

Зарчим 8: Бизнес эрхлэгчид нь байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэхэд идэвх санаачлагатай оролцоно.

Зарчим 9: Бизнес эрхлэгчид нь байгаль орчинд хоргүй технологийг дэлгэрүүлэх, хөгжүүлэхийг дэмжинэ.

#### **Авилга, хээл хахуулийн эсрэг:**

Зарчим 10: Бизнес эрхлэгчид нь луйвар, авилга, хээл хахуулийн бүх хэлбэрийг эсэргүүцэж ажиллана.

Уг баримтыг бүрэн эхээр нь НҮБ-ын Даян дэлхийн гэрээний албан ёсны сайт болох <http://www.unglobalcompact.org/>-ээс харна уу.

## **2. НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилга:**

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачлага нь НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр, санхүүгийн сектор хоёрын хоорондын хамтын ажиллагаа юм.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилгад өнөөгийн байгаль орчин, нийгэм, засаглалтай холбоотой асуудлуудыг ойлгон шийдлийг олох зорилгын дор нийт 230 гаруй санхүүгийн байгууллагууд хамтран ажилладаг байна.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилга нь бүс нутгийн үйл ажиллагаа, цогц ажлын хөтөлбөр, сургалтын хөтөлбөр болон судалгаа хийх замаар бүх түвшний санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд тогтсон практик болон байгаль орчны хамгийн сайн баталгааг хэрэгжүүлэх, хөгжүүлэх, нэгтгэхийн тулд өөрийн үүрэг даалгаврыг хэрэгжүүлдэг байна.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилгад нэгдэхийг хүссэн аливаа санхүүгийн байгууллага нь дараах тогтоолд гарын үсэг зурах ёстой.

- НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Санхүүгийн байгууллагуудын тогтвортой хөгжлийн талаар хүлээх үүрэг амлалтын тунхаг бичиг

Тогтоолд гарын үсэг зурсан байгууллагууд хэрэгжүүлж буй бүх үйл ажиллагаандаа байгаль орчны талаарх авах арга хэмжээнүүдээ нэгтгэж цогц болгох үүрэг хүлээнэ.

Уг баримтыг бүрэн эхээр нь НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санаачилгын албан ёсны сайт болох <http://www.unepfi.org/about/unep-fi-statement/> -ээс харах боломжтой болно.

## **3. Үндэстэн дамнасан корпораци болон нийгмийн бодлогын талаарх Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зарчмын гурван талт тунхаглал**

Үндэстэн дамнасан корпораци болон нийгмийн бодлогын талаарх Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зарчмын гурван талт тунхаглал нь үндэсний болон үндэстэн дамнасан корпорацид эдийн засаг болон нийгмийн үйл ажиллагаанд эерэг хувь нэмэр оруулах, түүнчлэн төрөл бүрийн үйл ажиллагаандаа үүсч болох бэрхшээлүүдийг шийдвэрлэх, түүнийг багасгахын тулд холбогдох тогтвортой ажлын байрны зарчмыг сайн дурын үндсэн дээр батлахыг дэмждэг болно.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гэрээ, хэлэлцээрүүд нь ажил олголт, сургалт, ажил, амьдралын нөхцөл болон үйлдвэрлэлийн харилцаа, бодлогуудад ерөнхий чиглэл нь болж үйлчилнэ.

Энэхүү гурван талт тунхаглал нь ажил олголтыг дэмжих, ажлын байрны аюулгүй байдал, мэргэжлийн сургалт болон удирдамжийн төлөвлөгөө болон бүх талуудын

хоорондох хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх болон гомдолд холбогдох зөвлөгөөн зэргийг багтаасан хөдөлмөрийн харилцааны асуудлыг илүү нарийвчлан авч үзсэн байна.

Энэ нь хөдөлмөр эрхлэлт болон ажлын байрны нөхцөл рүү чиглэсэн бөгөөд илүү олон төрлийн субъектүүдэд хандсан зарчмыг өргөтгөн, холбогдох заалтуудыг нь нарийвчлан тусгасан байна.

Уг баримтыг бүрэн эхээр нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын албан ёсны сайт болох <http://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---dcomm/documents/normativeinstrument/kd00121.pdf> -ээс харах боломжтой болно.

#### **4. ОУСК-ын гүйцэтгэлийн стандарт:**

ОУСК нь Дэлхийн банкны гишүүн байгууллага болох хувийн секторын хөгжилд дэмжлэг, үйлчилгээ үзүүлдэг олон улсын байгууллага юм. ОУСК нь байгаль орчин болон нийгэмд үзүүлж буй нөлөөг багасгах зорилготой төслүүдийг идэвхтэй санхүүжүүлж оролцдог ба хэрэгжүүлж буй төсөл, түүнд тавигдах шаардлагаа зохион байгуулах үүрэг, хариуцлагын талаар тодорхойлж дараах төслүүдэд тавигдах Гүйцэтгэлийн 8 стандартыг батлан гаргажээ.

1. Гүйцэтгэлийн стандарт 1: Нийгэм, байгаль орчны эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, удирдлага
2. Гүйцэтгэлийн стандарт 2: Ажиллах хүч ба ажлын байрны нөхцөл
3. Гүйцэтгэлийн стандарт 3: Нөөцийг үр ашигтай ашиглаж, бохирдлоос урьдчилан сэргийлэх
4. Гүйцэтгэлийн стандарт 4: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал
5. Гүйцэтгэлийн стандарт 5: Газар чөлөөлөлт, албадан нүүлгэн суурьшуулалт
6. Гүйцэтгэлийн стандарт 6: Биологийн олон янз байдлын хамгаалал, амьд байгалийн нөөцийн тогтвортой удирдлага
7. Гүйцэтгэлийн стандарт 7: Нутгийн уугуул иргэд
8. Гүйцэтгэлийн стандарт 8: Соёлын өв

Эдгээр стандартуудыг бүрэн эхээр нь Олон улсын санхүүгийн корпорацийн албан ёсны сайт [https://www.ifc.org/wps/wcm/connect/Topics\\_Ext\\_Content/IFC\\_External\\_Corporate\\_Site/Sustainability-At-IFC/Policies-Standards/Performance-Standards](https://www.ifc.org/wps/wcm/connect/Topics_Ext_Content/IFC_External_Corporate_Site/Sustainability-At-IFC/Policies-Standards/Performance-Standards) холбоосоор харах боломжтой болно.

#### **5. Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн 8 зарчим:**

Монгол Улсын тогтвортой хөгжлийн асуудлуудад анхаарлаа хандуулж, банкуудад Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн бодлогын идэвхтэй оролцогч байхад нь туслах зорилгоор Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудыг боловсруулсан бөгөөд тус зарчмууд нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, багасгах, бий болохоос зайлсхийхийг эрмэлзэх, түүнчлэн улс

орны ногоон эдийн засгийн өсөлт, хөгжлийн зорилгод нийцсэн төсөл, бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүжүүлэхийг дэмжих замаар Монгол Улсын эдийн засгийн олон талт хөгжилд хувь нэмэр оруулах Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийг бий болгох нэг арга зам юм.

Зарчим 1: Байгаль орчноо хамгаалах

Бид хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй, шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.

Зарчим 2: Хүний эрх, нийгмийг хамгаалах

Бид хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөнө. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллана.

Зарчим 3: Соёлын өвийг хамгаалах

Бид Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн соёл, түүх, археологи, палентологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалан ажиллана.

Зарчим 4: “Ногоон эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих

Бид Монгол Улсын ногоон, цэвэр эдийн засагт хувь нэмэр оруулах төсөл болон бусад үйл ажиллагааг дэмжин ажиллана.

Зарчим 5: Санхүүгийн хүртээмжийг дэмжих

Бид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, санхүүгийн боловсрол олгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээг авах замаар Монгол Улсад санхүүгийн өргөн хүрээтэй тогтолцоог бий болгохыг дэмжин ажиллана.

Зарчим 6: Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих

Бид хориглосон жагсаалтанд багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, бид ёс суртахуунгүй, гэмт хэргийн шинж чанартай үйлдлийг үл тэвчих бодлого явуулж, ёс зүйтэй байх, компанийн засаглалтай холбоотой сайн туршлагуудыг дэмжих бодлого баримтлан ажиллана.

Зарчим 7: Ил тод байдал, хариуцлагыг дэмжих

Бид ил тод байдал, хариуцлагыг дэмжин, банкны Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах явдлыг дэмжин ажиллана.

Зарчим 8: Манлайлан үлгэрлэх

Бид харилцагчиддаа тавьж буй шаардлагыг өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, салбарын хувьд Монгол Улсыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд эерэг хөгжилд чиглүүлэн ажиллана.

## **6. Бүс ба Зам санаачилгын Ногоон хөрөнгө оруулалтын зарчмууд (Green Investment Principles for the Belt and Road Initiative):**

Бүс ба Замын хамарч буй улс орнуудад хэрэгжиж буй төслүүд байгаль орчинд ээлтэй, уур амьсгалд тэсвэртэй, нийгмийн оролцоог хангасан байж, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Парисын хэлэлцээрийн зорилтуудыг биелүүлэх үүднээс БНХАУ-ын Ногоон санхүүгийн үндэсний зөвлөл болон Лондон хотын Ногоон санхүүгийн санаачилга хамтран бусад олон улсын байгууллагуудын оролцоотойгоор энэхүү ногоон хөрөнгө оруулалтын зарчмуудыг боловсруулсан билээ.

ХХБанк нь тус зарчмуудад гарын үсэг зурж нэгдсэн бөгөөд эдгээр зарчмуудыг өөрсдийн хөрөнгө оруулалт болон үйл ажиллагаандаа баримтлан ажиллахыг зорино.

**Зарчим 1: Тогтвортой байдлыг компанийн засаглалд нэгтгэх**

Бид тогтвортой байдлыг өөрийн стратеги, байгууллагын соёлдоо нэгтгэнэ. Манай ТУЗ болон дээд түвшний удирдлагууд тогтвортой байдалтай холбоотой эрсдэлүүд болон боломжуудыг хараа хяналтдаа авч, цогц системийг бий болгон, чадварлаг боловсон хүчнийг томилж, өөрсдийн хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны уур амьсгал, байгаль орчин, Бүс ба Замын хамарч буй бүс нутагт нийгэмд үзүүлэх боломжит нөлөөллийг анхаарч хяналт тавьж ажиллах болно.

**Зарчим 2: Байгаль орчин, нийгэм, болон засаглалын эрсдэлүүдийг ойлгох**

Бид байгаль орчинтой холбоотой хууль дүрэм, зохицуулалт, тухайн бизнесийн салбарт холбогдох стандартууд болон төсөл хэрэгжиж буй улсын соёл болон нийгмийн нормыг судалж, илүү сайн ойлгож мэдэхийг зорино. Бид шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) эрсдэлүүдийг харгалзан үзэж, байгаль орчин, болон нийгэмд үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийж, эрсдэл бууруулах, удирдах төлөвлөгөөнүүдийг боловсруулан ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээг гуравдагч этгээдээс авна.

**Зарчим 3: Байгаль орчинтой холбоотой мэдээллээ тайлагнах**

Бид өөрсдийн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын цахилгаан зарцуулалт, хүлэмжийн хийн ялгарал (GHG), байгаль орчныг бохирдуулагч бодисын ялгарал, усны хэрэглээ болон ойгүйдэлд шинжилгээ хийж хөрөнгө оруулалтын шийдвэрүүддээ байгаль орчны стресс тест хийх арга замуудыг эрэлхийлнэ. Бид байгаль орчин, уур амьсгалтай холбоотой мэдээллээ илүү ил тод байлгах тал дээр тасралтгүй ажиллаж, Уур амьсгалтай холбоотой санхүүгийн мэдээллийн ил тод байдлын комиссийн зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа чандлан баримтална.

**Зарчим 4: Оролцогч талуудтай харилцах харилцааг сайжруулах**

Бид төрийн байгууллагууд, байгаль орчныг хамгаалах байгууллагууд, хэвлэл мэдээлэл, нөлөөнд өртөж болзошгүй иргэд, нийгэмлэгүүд гэх мэт оролцогч талуудтай мэдээлэл хуваалцах механизмыг бий болгон оролцогч талуудтай харилцаагаа сайжруулах бөгөөд маргаан, асуудал үүссэн тохиолдолд шийдвэрлэх механизмыг бий болгон иргэд, нийлүүлэгчид, харилцагчидтай үүссэн асуудал, маргааныг тухай бүр тохиромжтой байдлаар шийдвэрлэх болно.

#### Зарчим 5: Ногоон санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах

Бид ногоон төслүүдийг санхүүжүүлэхдээ ногоон бонд, ногоон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ABS), YieldCo, ялгарал дээр суурилсан санхүүжилт буюу emission rights-based financing, ногоон хөрөнгө оруулалтын сан гэх зэрэг ногоон санхүүгийн хэрэгслүүдийг илүү ашиглана. Бид мөн байгаль орчны хариуцлагын даатгал, гамшгийн даатгал гэх зэрэг ногоон даатгалын бүтээгдэхүүнүүдийг өөрсдийн байгууллагын байгаль орчны эрсдэлийг бууруулахад ашиглахыг зорино.

#### Зарчим 6: Ногоон нийлүүлэлтийн сүлжээний удирдлагыг ашиглах

Бид өөрсдийн нийлүүлэлтийн сүлжээний удирдлагадаа Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ) -ын хүчин зүйлүүдийг нэгтгэн авч үзэж, хүлэмжийн хийн ялгарал болон усны хэрэглээ болон амьдралын мөчлөгийн нягтлан бодох бүртгэл, зөвшөөрөгдсөн нийлүүлэгчдийн жагсаалт, гүйцэтгэлийн индексүүд, мэдээллийн ил тод байдал, өгөгдөл, мэдээллээ хуваалцах гэх мэт олон улсын шилдэг туршлагауудыг нэвтрүүлж өөрсдийн хөрөнгө оруулалт, хангамж, үйл ажиллагаандаа ашиглана.

#### Зарчим 7: Хамтын ажиллагаагаар дамжуулан чадавх суулгах

Бид олон талт байгууллагууд, судалгааны болон эрдэм шинжилгээний байгууллагатай идэвх санаачлагатай хамтран ажиллаж, байгууллагын бодлогын хэрэгжилт, системийн бүтэц, хэрэгслүүдийн хөгжүүлэлт болон энэхүү зарчмуудад тусгагдсан бусад зүйлсийг хөгжүүлэхэд шаардлагатай төсөв, боловсон хүчнээр хангана.

(ГЗ-ын 2019-11-05-ны А-19/600 тоот тушаалаар хавсралт 1-д 5 болон 6-р зүйл нэмэв)

## Хавсралт 2: Хориотой үйл ажиллагааны жагсаалт

Энэхүү Хавсралтад Банкны санхүүжүүлэхээс татгалзсан хориотой үйл ажиллагааны жагсаалтыг оруулсан болно.

Жич: ХХБанк нь архи тамхины бизнесийн худалдаа болон үйлдвэр нь нийт зээлийн багцын 10%-с хэтрэхгүй байхаар оруулсан.

ХХБанк нь дор дурдсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй:

1. Биологийн болон олон янз байдал, түүх соёлын өвийн хамааралтай Монгол улсын хууль тогтоомж болон олон улсын конвенцоор хориглосон аливаа үйл ажиллагаа. Тухайлбал:
  - ЮНЕСКО-ийн Дэлхийн өв соёлыг хамгаалах сайтууд ([whc.unesco.org](http://whc.unesco.org));
  - ЮНЕСКО-ийн Биомандалын сөөц ([portal.unesco.org/science](http://portal.unesco.org/science)); болон
  - Рамсар сайтууд ([www.ramsar.org](http://www.ramsar.org)): Олон улсын ач холбогдол бүхий намагшсан газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчин.
2. Монгол улс болон олон улсын хууль, конвенц, гэрээгээр хориглосон хууль бус гэж үздэг үйл ажиллагаа, үйлдвэрлэл болон худалдаа;
3. “Полифлорт бифенил<sup>1</sup>” агуулсан аливаа бүтээгдэхүүний үйлдвэрлэл буюу худалдаа;
4. Олон улсад хориглосон<sup>2</sup> пестицид, гербицид, эм зүйн бүтээгдэхүүн болон бусад аюултай бодисуудыг үйлдвэрлэх, тараах, зарах болон худалдаалах;
5. Олон улсад хориглосон chlorofluorocarbons (CFCs), halons, болон бусад озон задлагч бодисууд<sup>3</sup> болон үүнийг агуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах эсвэл худалдаалах;
6. Байгалийн нэн ховордсон, мөн CITES-ийн конвенцид багтах зэрлэг амьтан, түүний эд эрхтэн, ургамлын төрөл зүйлийн худалдаа
7. Галт зэвсэг ба дайны зэвсгийн үйлдвэрлэл, худалдаа;
8. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа (пиво, дарснаас бусад)<sup>4</sup>;
9. Тамхины үйлдвэрлэл, худалдаа<sup>5</sup>

<sup>1</sup> PCBs: Polychlorinated biphenyls нь ихээхэн хортой химийн бодисын бүлэг. PCBs нь 1950-1985 оны хоорондох нефтээр дүүрсэн цахилгаан трансформатор, конденсатор болон хуваарилах төхөөрөмжид агуулагдах нь элбэг.

<sup>2</sup> Роттердамын Конвенц ([www.pic.int](http://www.pic.int)) болон Стокгольмын Конвенц ([www.pops.int](http://www.pops.int)) дээр заасан хэрэглээнээс гарсан эсвэл хориглосон зүйлс.

<sup>3</sup> Озон Задлагч Бодисууд (ОЗБ) нь стратосферын озонтой урвалд орж, түүнийг задалж “озоны цоорхой”-г үүсгэдэг химийн нэгдэл юм. Монреалын Протоколоор ОЗБ, түүний хэрэглээг багасган, хэрэглээнээс хасах өдрийг заасан. Монреалын протоколоор зохицуулагдах химийн нэгдэлд шүршигч шингэн, хөргөх бодис, хөөсрүүлэх бодис, уусгагч бодис, гал хамгаалах бодисуудыг оруулсан байна. ([www.unep.org/ozone/montreal.shtml](http://www.unep.org/ozone/montreal.shtml)).

<sup>4</sup> Эдгээр үйл ажиллагаануудад их хэмжээгээр оролцоогүй компаниудад энэ нь хамаарахгүй юм. “Их хэмжээгээр” гэдэг нь орлогын нэгдсэн балансын 10%-иас илүү хэмжээгээр ойлгоно. Санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулалтын сангийн хувьд “их хэмжээгээр” гэдэг нь тэдний өөрийн хөрөнгийн хэмжээний 10%-иас илүү хэмжээгээр ойлгоно.

<sup>5</sup> Эдгээр үйл ажиллагаануудад их хэмжээгээр оролцоогүй компаниудад энэ нь хамаарахгүй юм. “Их хэмжээгээр” гэдэг нь орлогын нэгдсэн балансын 10%-иас илүү хэмжээгээр ойлгоно. Санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулалтын сангийн хувьд “их хэмжээгээр” гэдэг нь тэдний өөрийн хөрөнгийн хэмжээний 10%-иас илүү хэмжээгээр ойлгоно.



10. Мөрийтэй тоглоом, казино болон адил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд;
11. Садар самуун, биеэ үнэлэхийг дэмжсэн сурталчилсан, зохион байгуулсан аливаа үйл ажиллагаа
12. Цацраг идэвхит бодисын/материал үйлдвэрлэл, худалдаа;
13. Шөрмөсөн чулуу ба үүнийг агуулсан аливаа бүтээгдэхүүнийг худалдах, үйлдвэрлэх, ашиглах;
14. Тогтвортой бус аргаар (жишээ нь: тэсрэх бодис ашиглан) болон 2.5 км-ээс “хөвөгч” урт тор ашиглан далайд загасчлах;
15. Албадан хөдөлмөрлөлт<sup>6</sup>, хор хөнөөлтэй хүүхдийн хөдөлмөрийн<sup>7</sup> мөлжлөг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн буюу үйл ажиллагаа, мөн ялгаварлан гадуурхал болон хуулинд заасан ажилчдын эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба хамтран хэлэлцээр байгуулах эрхийг хязгаарласан аливаа үйл ажиллагаа
16. Тропикийн бүсийн үндсэн чийглэг ой болон байгаль хамгааллын өндөр ач холбогдолтой ойн сан бүхий газраас мод бэлтгэх, мөн тухайн бүсэд мод бэлтгэлийн ажил хийхэд зориулагдсан тоног төхөөрөмжийн худалдаа хийх;
17. Ойжуулалтын тогтвортой удирдлаган дор хөгжүүлж байгаа ой модоос бусад газарт мод болон бусад ойн гаралтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх болон тэдгээрийг худалдаалах;
18. Холбогдох экспорт, импорт болон транзит орнуудаас авсан шаардлагатай экспорт, импортын гэрчилгээгүй, эсвэл дамжин өнгөрүүлж тээвэрлэх зөвшөөрөлгүй барааг наймаалцах
19. Сэтгэцэд нөлөөлөх ургамлын тариалан, хуулийн зохицуулалтгүй хар тамхины үйлдвэрлэл, тээвэрлэлт ба худалдаа
20. Сүлжээний маркетинг ба пирамидын бүтцээр дамжуулан орлого олох үйл ажиллагаа;
21. Олон улсын ба үндэсний тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа эрхлэх;
22. Олон улсад хориглосон хог хаягдлын тээвэрлэлт, устгал;
23. Олон улсын далайн байгууллага (ИМО)-ийн шаардлагад нийцэхгүй аюултай бодис, газрын тос тээвэрлэлт. Үүнд: тухайн тээврийн хөлөг онгоц нь MARPOL SOLAS-аас (ISM code буюу Олон улсын аюулгүй ажиллагааны удирдлага зэрэг, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) шаарддаг бүх шаардлагатай гэрчилгээ, зөвшөөрлийг аваагүй, тээврийн хөлөг онгоцуудыг Европын холбооноос хар дэвтэрт оруулсан, Усан боомтын дотоодын хяналтын Парисын харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу ашиглалтаас гаргасан, мөн MARPOL-ын журмын 13G-д заасны дагуу хэрэглээнээс хассан зэрэг орно. 25 жилээс дээш жил ашигласан ганц давхар хөлөг онгоцыг ашиглахгүй байна.

---

<sup>6</sup> Албадан хөдөлмөр эрхлүүлэх гэдэг нь хэн нэг этгээдийн заналхийлэл, хүч, шийтгэлийн дор сайн дураар бус хийж буй бүх ажил, үйлчилгээг хэлнэ.

<sup>7</sup> Хүүхдэд хортой хөдөлмөр гэдэг нь эдийн засгийн хувьд мөлжсөн, аюултай, хүүхдийн сурч боловсроход нь саад болох, хүүхдийн эрүүл мэнд, биеийн, оюун санааны, ёс зүйн болон нийгмийн хөгжилд хортой, аюултай байхыг хэлнэ.